



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН СУРГАЛТ, ҮНЭЛГЭЭ,
СУДАЛГААНЫ ИНСТИТУТЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2024/58/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: П.Чанцалдулам
Утас: 261885 Цахим хаяг: chantsaidulamp@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Мөнхжин
Утас: 261740 Цахим хаяг: munkhjind@audit.gov.mn
Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал: Т.Одончимэг
Утас: 70169029 Цахим хаяг: info@misheelodaudit.mn

Улаанбаатар хот
2024 он

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	8
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	15
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	16
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	17
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.5.1 Төсвийн төлөвлөлт	17
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	17
3.5.3 Нэмэлт төсөв	17
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	19
4. АУДИТЫН ТАЙЛАН	20
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.5.1 Завсрын аудитын талаар	21
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	22
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	22
5.1 Аудитаар хүргүүлсэн албан шаардлага	22
5.2 Аудитаар хүргүүлсэн зөвлөмж	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	27

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХНХ	Хөдөлмөр нийгмийн хамгаалал
ХНХСҮСИ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт үнэлгээ судалгааны институт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Улаанбаатар хот, Төвдүүдүүд
Сүхбаатар дүүрэг, Төвдүүдүүд
Утас: 26 04 17 Факс: 26 42 43

ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
СУРГАЛТ ҮНЭЛГЭЭ СУДАЛГААНЫ
ИНСТИТУТЫН ЗАХИРАЛ Б.БАТБААТАР
ТАНАА

2024.02.23 № 07/369
танай _____ ны № _____

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын өс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 320,964.5 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн боловч 206,106.3 мянган төгрөг бүрдүүлсэн нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 03/1681 дүгээр тушаалаар тус байгууллагыг мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх чиг үүргийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэлгүй болгож, Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад шилжүүлсэнтэй холбоотой орлого буурсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд 695,200.0 мянган төгрөгийн төсөвтэй Монгол улсын хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн таамаглал боловсруулах ажлыг хийж 2030 он хүртэлх хөдөлмөрийн зах зээлийн хүний нөөцийг тодорхойлох, шаардлагатай, эрэлттэй байх мэргэжлийн талаар тоон мэдээллийг бий болгосон байна.

0001051008

Жил бүр хийгддэг "Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн жил тутмын судалгааг хийж, үр дүнг тайлагнах" гэсэн ажлын үр дүн 50.0 хувийн гүйцэтгэлтэй байх ба уг судалгаагаар хөдөлмөрийн зах зээлийн ирэх нэг жилийн хэрэгцээ, өнгөрсөн нэг жилийн ажиллах хүчний хомсдолыг эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжил, байршлаар тодорхойлдог байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 68 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 90.3 хувийн биелэлттэй тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	256,907,015.38	168,933,977.40
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	300.00	-
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	300.00	-
31210	Төгрөг	300.00	-
31213	Арилжааны банк дахь харилцах	300.00	-
33	АВЛАГА	150,339,958.66	72,533,805.68
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,766,881.71	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	148,573,076.95	72,533,805.68
35	БАРАА МАТЕРИАЛ	106,566,756.72	96,400,171.72
35400	Хангамжийн материал	106,566,756.72	96,400,171.72
35410	Бичиг хэргийн материал	10,145,570.00	6,240,070.00
35420	Аж ахуйн материал	16,000.00	113,000.00
35470	Бусад хангамжийн материал	96,405,186.72	90,047,101.72
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,618,138,151.67	1,439,176,041.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,618,138,151.67	1,439,176,041.50
39200	Биет хөрөнгө	1,613,225,964.72	1,436,967,581.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,413,098,075.21	1,413,098,075.21
39202	Хуримтлагдсан элэгдэл	(239,775,035.02)	(278,194,175.98)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	218,077,700.00	95,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(218,077,700.00)	(95,200,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	678,494,764.93	663,185,009.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(401,472,625.34)	(489,697,670.20)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	359,906,290.57	356,397,824.68
39208	Хуримтлагдсан элэгдэл	(202,576,505.63)	(233,372,481.89)
39217	Ном	5,551,000.00	5,551,000.00
39300	Биет бус хөрөнгө	4,912,186.95	2,208,459.75
39301	Програм хангамж	95,908,611.79	16,573,201.79
39302	Хуримтлагдсан элэгдэл	(90,996,424.84)	(14,364,742.04)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,875,045,167.05	1,608,110,018.90
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,834,679.25	3,428,459.29
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,834,679.25	3,428,459.29
41300	Өглөг	2,834,679.25	3,428,459.29
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,834,679.25	2,758,459.29
41360	Бусад өглөг	-	670,000.00

**Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт үнэлгээ судалгааны институтын 2023 оны
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

41361	Байгууллагад төлөх өглөг	-	670,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,872,210,487.80	1,604,681,559.61
51	Засгийн газрын хувь оролцоо	1,872,210,487.80	1,604,681,559.61
51200	Хуримтлагдсан үр дүн	1,872,210,487.80	1,604,681,559.61
51210	Өмнөх үеийн үр дүн	-	1,872,210,487.80
51220	Тайлант үеийн үр дүн	1,872,210,487.80	(267,528,928.19)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,875,045,167.05	1,608,110,018.90

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт үнэлгээ судалгааны институтийн 2023 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,829,603,719.02	2,005,956,926.05
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,971,820,753.09	206,106,303.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,971,820,753.09	206,106,303.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	170,632,012.14	206,106,303.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	170,632,012.14	206,106,303.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,697,624,877.23	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	103,563,863.72	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	857,782,965.93	1,799,850,623.05
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	657,624,800.00	1,395,966,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	657,624,800.00	1,395,966,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	200,158,165.93	403,884,523.05
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	200,158,165.93	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	403,884,523.05
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	957,393,231.22	2,265,867,669.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	957,393,231.22	2,265,867,669.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	707,401,002.53	2,245,897,358.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	481,627,969.60	1,499,010,255.91
210101	Үндсэн цалин	306,570,446.94	798,876,178.51
210102	Нэмэгдэл	66,859,242.60	246,753,100.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	57,006,230.52	174,929,150.25
210104	Урамшуулал	28,395,195.00	35,951,933.74
210105	Гэрээт ажлын хөлс	22,796,854.54	242,499,892.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,832,479.01	147,326,980.10
210201	Тэтгэврийн даатгал	40,541,597.30	88,545,823.74
210202	Тэтгэмжийн даатгал	4,769,599.43	15,088,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,674,559.58	11,997,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	892,890.69	2,996,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,953,832.01	28,699,456.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,264,100.38	18,595,798.46
210301	Гэрэл, цахилгаан	1,733,911.57	6,591,591.06
210302	Түлш, халаалт	3,050,678.10	10,092,207.68
210303	Цэвэр, бохир ус	2,479,510.71	1,911,999.72

СНАГ-2024/58/НА-СТА-ТШЗ



**Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт үнэлгээ судалгааны институтийн 2023 оны
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210304	Байрны түрээс	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	28,276,351.10	115,174,594.00
210401	Бичиг хэрэг	15,917,880.00	72,757,300.00
210402	Тээвэр, шатахуун	1,535,000.00	11,221,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,781,958.10	22,597,306.00
210404	Ном, хэвлэл	-	6,152,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	77,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,041,513.00	2,369,088.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	200,000.00	65,350,080.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	200,000.00	35,750,080.00
210604	Урсгал засвар	-	29,600,000.00
2107	Томилолт, зочны зардал	381,200.00	37,949,939.00
210702	Дотоод албан томилолт	381,200.00	37,895,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	54,939.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,945,580.00	9,396,058.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	594,220.00	264,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	114,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	167,252.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	53,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,351,360.00	6,712,900.00
210807	Газрын төлбөр	-	84,506.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	120,873,322.44	353,093,653.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,889,861.88	26,434,282.81
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	32,367,135.00	134,084,245.51
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	85,616,325.56	192,575,125.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	249,992,228.69	19,970,310.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,438,036.00	15,124,263.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,180,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,257,436.00	15,124,263.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	191,554,192.69	4,846,047.28
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	191,554,192.69	4,751,115.28
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	94,932.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,872,210,487.80	(259,910,743.07)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	7,618,185.12
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	7,618,185.12
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,872,210,487.80	(267,528,928.19)

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт үнэлгээ судалгааны институтын 2023 оны
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан


2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,028,414,978.07	2,154,530,003.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	170,632,012.14	206,106,303.00
120	Нийтлэг татварын бус орлого	170,632,012.14	206,106,303.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	170,632,012.14	206,106,303.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	170,632,012.14	206,106,303.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	857,782,965.93	1,948,423,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	657,624,800.00	1,395,966,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	657,624,800.00	1,395,966,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	200,158,165.93	552,457,600.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	147,396,074.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	200,158,165.93	405,061,526.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,022,285,078.07	2,133,299,103.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,022,285,078.07	2,133,299,103.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	623,719,772.43	2,040,794,987.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	481,537,505.06	1,497,319,594.16
210101	Үндсэн цалин	306,570,446.94	798,543,240.26
210102	Нэмэгдэл	66,859,242.60	246,753,100.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	57,006,230.52	174,929,150.25
210104	Урамшуулал	28,395,195.00	35,951,933.74
210105	Гэрээт ажлын хөлс	22,706,390.00	241,142,169.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,832,479.01	147,326,980.10
210201	Тэтгэврийн даатгал	40,541,597.30	88,545,823.74
210202	Тэтгэмжийн даатгал	4,769,599.43	15,088,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,674,559.58	11,997,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	892,890.69	2,996,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,953,832.01	28,699,456.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,264,100.38	18,595,798.46
210301	Гэрэл, цахилгаан	1,733,911.57	6,591,591.06
210302	Түлш, халаалт	3,050,678.10	10,092,207.68
210303	Цэвэр, бохир ус	2,479,510.71	1,911,999.72
2104	Хангамж, бараа материалын зардал	27,775,999.10	95,293,243.00
210401	Бичиг хэрэг	10,920,316.00	42,803,950.00
210402	Тээвэр, шатахуун	389,000.00	11,221,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,781,958.10	22,597,306.00
210404	Ном, хэвлэл	3,948,000.00	6,152,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	77,000.00

СНАГ-2024/58/НА-СТА-ТШЗ



**Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт үнэлгээ судалгааны институтийн 2023 оны
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,736,725.00	12,441,087.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,233,600.00	68,243,080.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,233,600.00	38,643,080.00
210604	Урсгал засвар	-	29,600,000.00
2107	Томилолт, зочны зардал	381,200.00	38,466,070.00
210702	Дотоод албан томилолт	381,200.00	37,895,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	571,070.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,259,752.00	18,543,808.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,408,392.00	264,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	114,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	167,252.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	53,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,851,360.00	6,712,900.00
210807	Газрын төлбөр	-	84,506.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	9,147,750.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,435,136.88	157,006,413.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,621,936.88	22,922,167.81
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,813,200.00	134,084,245.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	398,565,305.64	92,504,115.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,438,036.00	15,124,263.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,180,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,257,436.00	15,124,263.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	340,127,269.64	77,379,852.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	191,554,192.69	4,751,115.28
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	148,573,076.95	72,628,737.68
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	6,129,900.00	21,230,900.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	6,129,600.00	21,231,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,129,600.00	21,231,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,129,600.00	21,231,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,129,600.00	21,231,200.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(6,129,600.00)	(21,231,200.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	300.00	(300.00)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	300.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	300.00	-


Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт үнэлгээ судалгааны институтын 2023 оны
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	1,872,210,487.80	1,872,210,487.80
9	Тайлант үеийн үр дүн	-	-	1,872,210,487.80	1,872,210,487.80
11	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,872,210,487.80	1,872,210,487.80
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	(267,528,928.19)	(267,528,928.19)
19	Тайлант үеийн үр дүн	-	-	1,604,681,559.61	1,604,681,559.61
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-

СНАГ-2024/58/НА-СТА-ТШЗ



**Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт үнэлгээ судалгааны институтийн 2023 оны
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,716,930,600.00	1,597,321,587.72	119,609,012.28	93.0
УРСГАЛ ЗАРДАЛ	1,716,930,600.00	1,597,321,587.72	119,609,012.28	93.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,701,806,300.00	1,582,197,324.72	119,608,975.28	93.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,327,268,000.00	1,256,177,425.16	71,090,574.84	94.6
Үндсэн цалин	820,235,800.00	798,543,240.26	21,692,559.74	97.4
Нэмэгдэл	324,630,100.00	246,753,100.91	77,876,999.09	76.0
Унаа хоолны хөнгөлөлт	105,832,100.00	174,929,150.25	(69,097,050.25)	165.3
Урамшуулал	76,570,000.00	35,951,933.74	40,618,066.26	47.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	188,670,000.00	147,326,980.10	41,343,019.90	78.1
Тэтгэврийн даатгал	128,295,600.00	88,545,823.74	39,749,776.26	69.0
Тэтгэмжийн даатгал	15,093,700.00	15,088,300.00	5,400.00	100.0
ҮОМШӨ-ний даатгал	12,074,900.00	11,997,200.00	77,700.00	99.4
Ажилгүйдлийн даатгал	3,018,600.00	2,996,200.00	22,400.00	99.3
Эрүүл мэндийн даатгал	30,187,200.00	28,699,456.36	1,487,743.64	95.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,539,800.00	18,595,798.46	2,944,001.54	86.3
Гэрэл, цахилгаан	7,225,500.00	6,591,591.06	633,908.94	91.2
Түлш, халаалт	10,966,400.00	10,092,207.68	874,192.32	92.0
Цэвэр, бохир ус	3,347,900.00	1,911,999.72	1,435,900.28	57.1
Хангамж, бараа материалын зардал	74,024,400.00	73,173,243.00	851,157.00	98.9
Бичиг хэрэг	41,715,300.00	41,704,950.00	10,350.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,855,500.00	18,950,206.00	905,294.00	95.4
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	77,000.00	(77,000.00)	
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,453,600.00	12,441,087.00	12,513.00	99.9
Эд хогшил, урсгал засварын зардал	54,757,100.00	54,056,400.00	700,700.00	98.7
Багаж, техник, хэрэгсэл	24,757,100.00	24,456,400.00	300,700.00	98.8
Урсгал засвар	30,000,000.00	29,600,000.00	400,000.00	98.7
Томилолт, зочны зардал	7,621,100.00	7,390,070.00	231,030.00	97.0
Дотоод албан томилолт	6,819,000.00	6,819,000.00	0.00	100.0
Зочин төлөөлөгч хүлээн авах	802,100.00	571,070.00	231,030.00	71.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,992,300.00	18,543,808.00	2,448,492.00	88.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,196,700.00	264,300.00	932,400.00	22.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,857,000.00	2,000,000.00	857,000.00	70.0
Даатгалын үйлчилгээ	540,400.00	114,100.00	426,300.00	21.1
Тээврийн хэрэгслийн татвар	382,300.00	167,252.00	215,048.00	43.7
Тээврийн хэрэгслийн оношлогоо	53,100.00	53,000.00	100.00	99.8

**Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт үнэлгээ судалгааны институтийн 2023 оны
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,717,700.00	6,712,900.00	4,800.00	99.9
Газрын төлбөр	95,700.00	84,506.00	11,194.00	88.3
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,149,400.00	9,147,750.00	1,650.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	6,933,600.00	6,933,600.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	6,933,600.00	6,933,600.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,124,300.00	15,124,263.00	37.00	100.0
Бусад урсгал шилжүүлэг	15,124,300.00	15,124,263.00	37.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,124,300.00	15,124,263.00	37.00	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,716,930,600.00	1,597,321,287.72	119,609,312.28	93.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,395,966,100.00	1,391,214,984.72	4,751,115.28	99.7
Улсын төсвөөс санхүүжих	1,395,966,100.00	1,391,214,984.72	4,751,115.28	99.7
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	320,964,500.00	206,106,303.00	114,858,197.00	64.2
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	320,964,500.00	206,106,303.00	114,858,197.00	64.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	
АЖИЛЛАГСДЫН ТОО	75	59	16	78.7
Удирдах ажилтан	4	4	0.00	100.0
Гүйцэтгэх ажилтан	67	51	16	76.1
Үйлчлэх ажилтан	4	4	0.00	100.0

СНАГ-2024/58/НА-СТА-ТШЗ



2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	552,457,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	552,457,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	479,828,862.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	241,142,169.00
210105	Гэрээт ажлын хөлс	241,142,169.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,120,000.00
210401	Бичиг хэрэг	1,099,000.00
210402	Тээвэр, шатахуун	11,221,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,647,100.00
210404	Ном, хэвлэл	6,152,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,417,880.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	35,417,880.00
2107	Томилолт, зочны зардал	31,076,000.00
210702	Дотоод албан томилолт	31,076,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	150,072,813.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,988,567.81
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	134,084,245.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,628,737.68
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	72,628,737.68
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	72,628,737.68
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	552,457,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	552,457,600.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	147,396,074.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	405,061,526.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны эрхэм зорилго нь төрөөс хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, хөтөлбөрийн судалгаа, шинжилгээ хийж, бодлого боловсруулагч нарт зориулсан зөвлөмж боловсруулах, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг тодорхойлох, түүнд нийцүүлэн хүний нөөцийг бэлтгэх, хөдөлмөрт бэлтгэх, ур чадварыг олгох, сургалт, бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, үнэлгээ, чанарын баталгаажуулалт хийхэд оршино.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт нь Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт;
- Засгийн газрын 2022 оны 203 дугаар тогтоолоор баталсан "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай";
- Засгийн газрын 2023 оны өдрийн 241 дүгээр тогтоолоор баталсан Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай;
- Засгийн газрын 2022 оны 448 дугаар тогтоолоор баталсан "Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай";
- Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам";

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын дотоод аудитын чиг үүргийг ХНХЯ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хэрэгжүүлдэг боловч тайлант жил аудит хийгээгүй тул дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Хөдөлмөр, нийгэм хамгааллын яамны Төрийн нарын бичгийн даргын 2017 оны А/270 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт үнэлгээ судалгааны институтын 2023 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

санхүүгийн үйл ажиллагаандаа мөрддөг гэсэн боловч аудитын явцад ирүүлээгүй тул танилцаж чадаагүй болно.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 266,935.2 мянган төгрөгөөр буюу 14.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.3	0.00	(0.3)
Авлага	150,340.0	72,533.8	(77,806.2)
Бараа материал	106,566.8	96,400.2	(10,166.6)
Үндсэн хөрөнгө	1,618,138.1	1,439,176.0	(178,962.1)
Нийт хөрөнгө	1,875,045.2	1,608,110.0	(266,935.2)
Өр төлбөр	2,834.7	3,428.4	593.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,872,210.5	1,604,681.6	(267,528.9)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,875,045.2	1,608,110.0	(266,935.2)

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансдууд байна.

Авлагын данс өмнөх оноос 77,806.2 мянган төгрөгөөр буурсан нь татаас санхүүжилтийн авлага 72,533.8 мянган төгрөг болж буурсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 10,165.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор нийт 80,382.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 90,549.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 178,962.1 мянган төгрөгөөр буурсан нь ХНХСҮСИ-ээс Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 26 тогтоолоор 89,895.0 мянган төгрөгийн үнэтэй Land rover defender суудлын авто машиныг балансаас балансад шилжүүлж, 32,982.7 мянган төгрөгийн үнэтэй Соната-7 суудлын автомашиныг дуудлага худалдаагаар худалдаж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/2464 дүгээр албан бичгийн дагуу 119,384.8 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, тайлант хугацаанд тооцсон 192,575.1 мянган төгрөгийн элэгдлийн зардалтай тус тус холбоотой байна.

Богино хугацаат өглөгийн дүн 593.8 мянган төгрөгөөр өссөн нь “Үндэсний үнэт цаас” ХХК-нд чадамжийн гэрчилгээний үнийг төлөөгүйтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл тайлант оны үр дүн 267,528.9 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь төсвийн төслийн саналыг боловсруулж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлээгүй байна.

Тайлант онд улсын төсвөөс 1,021,918.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагаанаас 360,964.5 мянган төгрөг, нийт 1,382,882.6 мянган төгрөгийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг баталсан байна.

Батлагдсан төсвийг 2024 оны 7 дугаар сард тодотголоор 374,048.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,756,930.6 мянган төгрөг, 12 дугаар сард 40,000.0 мянган төгрөгөөр бууруулж, 1,716,930.6 мянган төгрөг болгон баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,395,966.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 320,964.5 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээс гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,395,966.1 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлогоос 206,106.3 мянган төгрөгийг бүрдүүлж, 4,751.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,597,321.6 мянган төгрөг буюу 93.0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 119,609.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна. Тухайлбал: цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 71,090.6 мянган төгрөг, НДШ-ийн зардлыг 41,343.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2,944.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
72102	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	1,716,930.6	1,597,321.6	119,609.0	93.0
80101	Үндсэн үйл ажиллагаа	1,701,806.3	1,582,197.4	119,608.9	93.0
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, дэмжлэг	15,124.3	15,124.2	0.1	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 405,061.5 мянган төгрөг, татаас санхүүжилтийн авлагад бүртгэсэн 147,396.1 мянган төгрөг, нийт 552,457.6 мянган төгрөгийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлжээ. Үүнээс гэрээт ажлын цалинд 241,142.2 мянган төгрөг, хангамжийн бараа материалд 22,120.0 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 35,417.9 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 31,076.0

мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 150,072.8 мянган төгрөг, нийт 479,828.9 мянган төгрөгийг зарцуулж, 72,628.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант хугацаанд төсөвт байгууллагын үйл ажиллагаатай холбоотой худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй бөгөөд "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан"-ийн хүрээнд 910,128.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулж, 845,003.5 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой үндсэн хөрөнгийн бүртгэлд тавих дотоод хяналтыг сайжруулах, хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг мөрдөж ажиллах, Татварын байгууллагатай татварын тооцооны үлдэгдлийг баталгаажуулахтай холбоотой өгсөн 5 зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Мишээл-Од Аудит ХХК-ийн газрын ахлах аудитор П.Энхцэлмэг, аудитор М.Цэнд-Аюуш, аудиторын туслах Э.Ундрах-Эрдэнэ, Х.Гэрэлбаяр, Т.Алтанчимэг, Э.Нямдулам нар гүйцэтгэж, аудитын менежер Э.Энхцэцэг, захирал, тэргүүлэх аудитор Т.Одончимэг нар анхан шатны хяналтыг, Үндэсний аудитын газрын ахлах аудитор Д.Мөнхжин, аудитын менежер П.Чанцалдулам, Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний Аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02/141 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсвийн төлөвлөгөөний нийт зарлага 1,756,930.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 26,353.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж 1,716,930.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 25,753.9 мянган төгрөг болгон шинэчлэн тогтоосон байна.

3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ТӨБЗГ-т 2 машин шилжүүлж тээврийн хэрэгслийн татвар 215.0 мянган төгрөг даатгал 426.0 мянган төгрөг нийт 641.3 мянган төгрөгийн төсвийг хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт үнэлгээ судалгааны институтийн 2023 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаанд нь оруулсан 167, хугацаа болоогүй 2, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 29 удаагийн 1,918,955.9 мянган төгрөгийн орлого, 17 удаагийн 233,016.0 мянган төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" 6 дугаар зүйлийн 6.4. "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ." 6.4.5."цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"; гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг иж бүрэн, хуулийн хугацаанд нь байршуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2023 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, нэмэлт санхүүжилтийн данс, цалин хөлстэй холбоотой дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулж, төсвийн гүйцэтгэлийн тайланд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 13,200.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байсныг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн 1 албан шаардлага, 5 зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэхэд хэрэгжилт 80.0 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	500.0	1	500.0	100
Зөвлөмж	5	7,272.1	3	4,474.9	60
Нийт дүн	6	7,772.1	4	4,974.9	80

Өмнөх аудитаар өгөгдсөн дараах 2 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй тул Монгол улсын ерөнхий аудиторын баталсан 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан журмын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын төлбөр, тооцоог тухай бүр хийж, тооцоо нийлж баталгаажуулан төсвийг зохистой удирдаж ажиллах зөвлөмж өгсөн боловч тайлант онд татварын өглөгтэй, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, ил тод байршуулж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд мэдээллүүдийг хугацаа хоцроож байршуулсан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ур чадварын нэмэгдлийг нийт 65 ажилтнаас 59 ажилтанд сар бүр 10-25 хувиар тооцож ажилтнуудын ур чадварыг тодорхой үнэлээгүйгээр олгосон нь Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор албан хаагчийн ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвх санаачилгыг дэмжиж, үр бүтээлтэй ажиллуулах зорилгоор ур чадварын нэмэгдэл олгоно гэсэн заалттай нийцэхгүй байна гэж үзэж дараагийн аудитаар анхаарах асуудлаар авч үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 95,330.7 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналыг алдаатай илэрхийлэгдсэн 3 удаагийн 95,330.7 мянган төгрөгийн алдаа нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 27-д Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой гэж заасантай нийцэхгүй байгаа учир залруулга хийж, санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайлан, Үр дүнгийн тайланд улсын төсвийн санхүүжилтээс төвлөрүүлсэн 77,379.6 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох санхүүжилтээс төвлөрүүлсэн шилжүүлгийн зардалд тусгасан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 13,200.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.
- Мөнгөн гүйлгээний тайланд төвлөрүүлэх шилжүүлгийн тохируулга хийгээгүйгээс Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт орлогыг 4,751.1 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.

Аудитаар нийт 33,515.7 мянган төгрөгийн 8 зөрчил² илэрснээс 8,032.1 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 25,483.6 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 33,515.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа нь материаллаг бус алдаа гэж үзэж "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Аудитаар хүргүүлсэн албан шаардлага

1. Илрүүлэлт:

Өмнөх аудитаар "Хувь хүний орлогын албан татварын төлбөр, тооцоог тухай бүр хийж, тооцоо нийлж баталгаажуулан төсвийг зохистой удирдаж ажиллах" гэсэн зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд татварын өртэй тайлагнасан, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3. "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Илрүүлэлт:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 12-р сарын 19-ний өдрийн А-1/2464 тоот албан бичгийн хавсралт дах 4,832.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасах байтал тус хөрөнгүүд нь бусад хангамжийн материалд бүртгэлтэй байсан мөн өмнөх жилүүдэд данснаас

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хасагдсан хөрөнгүүд давхар тоологдож дансанд бодитоор оршин байхгүй хөрөнгийг данснаас хасах хүсэлт хүргүүлсэн байна.

Энэ нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 27-д Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Үндсэн хөрөнгийн тооллогыг хариуцлагатай, чанартай, үнэн зөв тоолж, нягтлан бодох бүртгэлд тайлагнаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Илрүүлэлт:

Тайлант онд үндсэн үйл ажиллагаатай хамааралгүй, хэмнэж болох 3,200.0 мянган төгрөгийн спортын хувцас хэрэглэлийг худалдан авсан байна.

Энэ нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 27-д Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "үр ашигтай байх", 4.2.1-д "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой дараах зөрчил байна. Үүнд:

- Тайлант хугацаанд нийт 177,949.7 мянган төгрөгийн анхны өртөг бүхий 28 нэр төрлийн хөрөнгийн тайлант жилийн элэгдлийн зардлыг 19,631.7 мянган төгрөгөөр дутуу мөн 3 нэр төрлийн хөрөнгөнд элэгдэл байгуулаагүй;
- Ашиглалтын хугацаа дууссан 3 нэр төрлийн хөрөнгөд 2,584.9 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг илүү тооцож, байгуулсан;
- 140,480.0 мянган төгрөгийн 4 нэр төрлийн хөрөнгийн ашиглалтын хугацаа бодит бус ба ижил төрлийн хөрөнгүүдийн ашиглалтын хугацааг өөрөөр бүртгэсэн зэрэг байна.
- Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 92 нэр төрлийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа боловч дахин ашиглагдах боломжтой үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.

Энэ нь УСНББОУС-ын 17 Үндсэн хөрөнгийн стандартын 66 дахь зүйлд зааснаар хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид системчилсэн сууриар хуваарилна, 67

дахь зүйлд зааснаар хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4-т "Үнэн зөв байх", 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэх, элэгдлийг зөв тооцож бүртгэлд тусгаж байх.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн бүртгэлд газар эзэмших эрхийг үнэлж тусгаагүй ба газар эзэмших эрхийн гэрчилгээг гаргуулан аваагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 3 дугаар зүйлийн 3.8-д "Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмыг мөрдөж Сонгинохайрхан дүүрэгт байрлах газрыг үнэлэн бүртгэлд тусгаж, газар эзэмших эрхийн гэрчилгээг гаргуулан авах.

3. Цалин хөлстэй холбоотой асуудлаар

Илрүүлэлт:

Цалин хөлсний тооцоолол, бүртгэл, тайлагналтай холбоотой дараах зөрчил байна. Үүнд:

1. Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварын өглөг татварын тооцооллоор 1,956.9 мянган төгрөг байхад санхүүгийн тайланд 1,113.1 мянган төгрөг буюу 843.9 мянган төгрөгөөр өглөг дутуу тайлагнасан байна. Мөн Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын авлага татварын тооцооллоор 600.0 мянган төгрөг байхад санхүүгийн тайланд авлага тайлагнаагүй буюу татварын авлагыг 600.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.
2. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан орлогын албан татварын тайланд 1,823.1 мянган төгрөгийн цалинг илүү тайлагнасан байна.

Энэ нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 27-д Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4-т "Үнэн зөв байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг мөрдөж ажиллах, Татварын байгууллагатай татварын тооцооны үлдэгдлийг баталгаажуулж байх.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт үнэлгээ судалгааны институтын 2023 оны
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 02-ны
өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн		
							Тоо	Дүн	Тоо	Дүн				
Мөнгөн гүйлгээний тайлан, Үр дүнгийн тайланд улсын төсвийн санхүүжилтээс төвлөрүүлсэн 77,379.582.96 төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох санхүүжилтээс төвлөрүүлсэн шилжүүлгийн зардалд тусгасан байна.	1	77,379.6					1	77,379.6						
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 13,200,000.00 төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	1	13,200.0					1	13,200.0						
Мөнгөн гүйлгээний тайланд төвлөрүүлэх шилжүүлгийн тохируулга хийгээгүйгээс Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт орлогыг 4,751,115.28 төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	4,751.1					1	4,751.1						
Дүн	3	95,330.7	0	0.0	0	0.0	3	95,330.7	0	0.0	0	0.0	0	0.0

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт үнэлгээ судалгааны институтын 2023 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зөрчлийн товч утга												
Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 92 нэр төрлийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа боловч дахин ашиглагдах боломжтой үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.	1						1					
Тайлант хугацаанд нийт 177,949.7 мянган төгрөгийн анхны өртөг бүхий 28 нэр төрлийн хөрөнгийн тайлант жилийн элэгдлийг 19,631.7 мянган төгрөгөөр дутуу ба үүнээс 3 нэр төрлийн хөрөнгө нь тайлант онд элэгдэл байгуулаагүй байна. Мөн ашиглалтын хугацаа дууссан 3 нэр төрлийн хөрөнгөд 2,584.9 мянган төгрөгийн тайлант жилийн элэгдлийг илүү байгуулсан байна. Мөн 140,480.0 мянган төгрөгийн 4 нэр төрлийн хөрөнгийн ашиглалтын хугацаа бодит бус ба ижил төрлийн хөрөнгүүдийн ашиглалтын хугацааг өөрөөр бүртгэсэн байна.	1	22,216.6					1	22,216.6				

01
 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
 БОРИЛЛОЛТГУЙ
 САНАЛ ДҮГНЭЛТ 28

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт үнэлгээ судалгааны институтын 2023 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 12-р сарын 19-ний өдрийн А-1/2464 тоот албан бичгийн хавсралт дахь 4,832.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасах байтал тус хөрөнгүүд нь бусад хангамжийн материалд бүртгэлтэй байсан мөн өмнөх жилүүдэд данснаас хасагдсан хөрөнгүүд давхар тоологдож дансанд бодитоор оршин байхгүй хөрөнгийг данснаас хасах хүсэлт хүргүүлсэн байна.	1	4,832.1	1	4,832.1			
Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварын өглөг татварын тооцооллоор 1,956.9 мянган төгрөг байхад санхүүгийн тайланд 1,113.1 мянган төгрөг буюу 843.9 мянган төгрөгөөр өглөг дутуу тайлагнасан байна. Мөн Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын авлага татварын тооцооллоор 600.0 мянган төгрөг байхад санхүүгийн тайланд авлага тайлагнаагүй буюу татварын авлагыг 600.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	1	1,443.9	1	1,443.9			
Өмнөх аудитаар "Хувь хүний орлогын албан татварын төлбөр, тооцоог тухай бүр хийж, тооцоо нийлж баталгаажуулан төсвийг зохистой удирдаж ажиллах" гэсэн зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд татварын өртэй тайлагнасан, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	-	1	-			
Үндсэн хөрөнгийн бүртгэлд газар эзэмших эрхийг үнэлж тусгаагүй ба газар эзэмших эрхийн гэрчилгээг гаргуулан аваагүй байна.	1	-	1	-			
Цалин Хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан орлогын албан татварын тайланд 1,823.1 мянган төгрөгийн цалинг илүү тайлагнасан байна.	1	1,823.1	1	1,823.1			

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт үнэлгээ судалгааны институтын 2023 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тайлант онд үндсэн үйл ажиллагаатай хамааралгүй, хэмнэж болох 3,200.0 мянган төгрөгийн спортын хувцас хэрэглэлийг худалдан авсан байна.	1	3,200.0			1	3,200.0				
Дүн	8	33,515.7	0	0.0	3	8,032.1	5	25,483.6	0	0.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил				Үүнээс			
	Нийт зөрчил		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил Өмнөх аудитаар "Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, ил тод байршуулж байх" гэсэн зөвлөмж өгсөн боловч тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийг иж бүрэн оруулаагүй буюу Тайлант хугацаанд нь оруулбал зохих 171 мэдээллээс 167 мэдээллийг хугацаанд нь оруулсан ба хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс Дээш үнийн дүн бүхий 29 удаагийн 1,918,955.9 мянган төгрөгийн орлого, 17 удаагийн 233,016.0 мянган төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг шилэн дансанд хугацаа хоцроож байршуулсан байна.	1	2,151,971.90	1	2,151,971.90				
Дүн	1	2,151,971.90	1	2,151,971.90				





МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТЫН ГАЗАР
ХАМГААЛЫН ШААРДЛАГА

2024 - 02 - 09

239/40150061
СНАГ - 2024/53/АА - СГА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаанд нь оруулсан 167, хугацаа болоогүй 2, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 29 удаагийн 1,918,955,900.00 /Нэг тэрбум есөн зуун арван найман сая есөн зуун тавин таван мянга есөн зуун/ төгрөгийн орлого, 17 удаагийн 233,016,000.00 /Хоёр зуун гучин гурван сая арван зургаан мянган/ төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг Шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" 6 дугаар зүйлийн 6.4. "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр": гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг иж бүрэн, хуулийн хугацаанд нь байршуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн захирал /Б.Батбаатар/, ерөнхий нягтлан бодогч /Б.Пүрэвцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.ОДОНЧИМЭГ

0001060799



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024

62

23

295/АУТБ/2024

СНАГ-2024/52/НА-СТ-7123

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар "Хувь хүний орлогын албан татварын төлбөр, тооцоог тухай бүр хийж, тооцоо нийлж баталгаажуулан төсвийг зохистой удирдаж ажиллах" гэсэн зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд татварын өртэй тайлагнасан, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3. "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын захирал /Б.Батбаатар/, ерөнхий нягтлан бодогч /Б.Пүрэвцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.ОДОНЧИМЭГ

0001069791



МОНГОЛ УЛСЫН ШААРДЛАГА
АЛБАН ШААРДЛАГА

2024

02

23

291/40150001

САГА - 2024/03/14А - СТ4 - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ Үүнд:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 12-р сарын 19-ний өдрийн А-1/2464 тоот албан бичгийн хавсралт дах 4.832.100.00 /Дөрвөн сая найман зуун гучин хоёр мянга нэг зуун/ төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасах байтал тус хөрөнгүүд нь бусад хангамжийн материалд бүртгэлтэй байсан мөн өмнөх жилүүдэд данснаас хасагдсан хөрөнгүүд давхар тоологдож дансанд бодитоор оршин байхгүй хөрөнгийг данснаас хасах хүсэлт хүргүүлсэн байна.

Энэ нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 27-д Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2 хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй, 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үндсэн хөрөнгийн тооллогыг хариуцлагатай, чанартай, үнэн зөв тоолж, нягтлан бодох бүртгэлд тайлагнаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн захирал /Б.Батбаатар/, ерөнхий нягтлан бодогч /Б.Пүрэвцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас: 51-264230

2. Албан шаардлага 2024-0223-0016001-0001

0001069793



ҮНДЭСНИЙ АУДИТЫН АХУЙН
АЛБАН ШААРДЛАГА

2024

02

23

232/АУИС/001

СНАГ-2024/53/МЧ-СГА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд үндсэн үйл ажиллагаатай хамааралгүй, хэмнэж болох 3,200,000.00 /Гурван сая хоёр зуун мянган/ төгрөгийн спортын хувцас хэрэглэлийг худалдан авсан байна.

Энэ нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 27-д Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "үр ашигтай байх", 4.2.1-д "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11. "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын захирал /Б.Батбаатар/, ерөнхий нягтлан бодогч /Б.Пүрэвцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.ОДОНЧИМЭГ